

зохион байгуулах нь хил хамгаалалтын хувьд ихээхэн ач холбогдолтой болно. Хилийн Цэргийн одоогийн хүч хэрэгсэл, төсвийн байдал, инженерийн арга хэмжээг шаардлагатай түвшинд байлгах боломж хомс тул хилчдийг морь, тэмээ, туулц сайтай автомашин мотоциклоор хангах, нисдэг тэрэг хил хамгаалалтад ашиглаж байсан уламжлалыг сэргээх нь инженерийн халхлалтын орон зайг нөхөхөд чухал ач холбогдолтой болно. Энэ бүгдээс дүгнэн үзэхэд Монгол Улсын хил хамгаалалт нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хилийн тухай тогтоомжийг хэрэгжүүлэхээр эрх бүхий байгууллагаас явуулж буй улс төр дипломат, эрх зүй, хилийн хяналт, тагнуул, цэргийн болон инженер-техникийн арга хэмжээнүүдийн цогцолбор ажиллагаа гэж тодорхойлж болох юм.

*

*

*

*ХИЦС-ийн ШНА-ны тэнхимийн
ахлах багш дэд хурандаа Г.Төртөгтох*

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООНД ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНЫ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Монгол Улсын төрөөс баримтлах хилийн бодлогын үндсэн нэн чухал зорилго бол улсын хил болон хязгаар нутагт улс, үндэсний аюулгүй байдлыг хангах явдал мөн. Харамсалтай нь энэ бодлого өнөөг хүртэл байхгүй байна. Монгол Улсын тусгаар тогтнол, бие даасан байдал болон бүрэн бүтэн байдал нь түүний хилийн тогтонги чанар, найдвартай хамгаалалттай шууд холбоотой байдаг.

Өнөөг хүртэл бидний ярьж хэвшсэн улсын хил хамгаалалт гэдгийг өргөн утгаар нь *улсын хилийн аюулгүй байдлыг хангах* гэж томъёолж болно гэж үзэж байна. Тэгвэл хилийн аюулгүй байдал нь улс үндэсний аюулгүй байдлын нэг үндсэн бүрэлдэхүүн хэсэг байх ёстой. Аливаа улс орны тогтвортой байдал нь түүний хилийн аюулгүй байдалтай нягт холбоотой байдаг. Үндэсний аюулгүй байдалд хилийн аюулгүй байдлын эзлэх байр суурийг доорхи байдлаар бүдүүвчид тусгаж болох юм.



Монгол Улсын аюулгүй байдлын үзэл баримтлалд: Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдал: ... Улсын хилийг өөрчлөх, хууль бусаар хил нэвтрэх, хилийн зөрчил гаргах

Хилийн аюулгүй байдлыг хангах шаардлага нь бодит нөхцөл байдал дээр үндэслэгддэг. Тухайлбал:

Хүн төрөлхтөн буй болоод 50 000 жил болж байгаагийн 40 000 жилийг нь агуйд өнгөрөөж, сүүлийн 10 000 жилд нь агуйгаас гарч амьдарч хөгжсөөр өнөөгийн соёл иргэншлийг бий болгосон түүхтэй. Энэ хугацаанд дэлхий дээр хүний 800 үе солигдон өнгөрсний 650 үе нь агуйд амьдралаа дуусгасан байна. Агуйгаас гарч амьдарсан сүүлийн 150 үеийнхний хувьд нутаг ус, эзэмшил газар, улс орон, хил хязгаар, өөр хоорондын хил хязгаарыг нэвтрэх, зорчих үйл ажиллагаа тодорхой харилцан тохиролцоо, гэрээний дагуу явагдаж иржээ.

Гүн ухааны онолын “Үгүйсгэл үгүйсгэлийн” хуулийн дагуу зарим улс үндэстэн устгах, салах, өөр хоорондоо нэгдэх, шинээр улс орон бий болох үйл явц явагдсаны хэрээр улсын хил, хилийн боомтын үүсэл хөгжил энэ жамаар явж иржээ. Мөн урьд нь хамгийн их ач холбогдолтой байсан улсын хил, хилийн боомтууд, цагийн аясаар аль нэгэн цагт хамгийн ач холбогдолгүй болж хувирах, дахин сэргэх үзэгдэл ч байсан нь эргэлзээгүй.

Амьтанжих онолын үүднээс авч үзвэл чухал ач холбогдолтой байсан улсын хил, хилийн боомтууд нь хөгжин бэхжиж, ач холбогдол багатай байсан нь хаагдаж, өнөөдөр түүх болон хоцорчээ.

Улс төрийн онолын үүднээс авч үзвэл улсын хил, хилийн боомтууд нь улс орнуудын хоорондын харилцаанаас ихээхэн хамааралтай байдаг байна.

Иймээс улсын хилийн аюулгүй байдлын шаардлага нь улс орнууд бий болох, тэдгээрийн газар нутгийг зааглах үйл явц, өөрсдийн нутаг дэвсгэрийн хязгаарт хил, улсын тусгаар тогтнолыг тогтоох ба хадгалахын хууль ёсны үр дүн болдог. Мөн түүнчлэн хилийн аюулгүй байдал нь бий болж болзошгүй дараахь зүйлүүдэд үндэслэгддэг:

- Нэг талын буюу хоёр талын газар нутгийн маргаан,
- Хилийн маргаан хурцдах,
- Маргаан нь зэвсэгт хүчирхийлэлд шилжих зэрэг болно.

Үүнээс гадна төрийн салшгүй нэг үйл ажиллагаа нь улсын хил дээр болон хил орчмын нутаг дэвсгэрт үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг хамгаалах, түүнд заналхийлсэн аливаа үйлдлийн эсрэг арга хэмжээ авах явдал цаг үргэлж байсан бөгөөд байсаар ч байна. Цаашид ч байх нь эргэлзээгүй юм.

Илтгэлийнхээ оршил болгон өгүүлсэн зүйлээсээ үндэслэн улсын хил хамгаалалтын тогтолцоог дараахь бүдүүвчээр томъёолж байна.

Улсын хил хамгаалалтын тогтолцоо



Улсын хил хамгаалалтын тогтолцоо нь бүтцийн хувьд зорилгын, агуулгын, арга технологийн, боловсон хүчний, эдийн засгийн, эрх зүйн, удирдлагын болон хил хамгаалалтын байгууллагын дэд тогтолцооноос бүрдэх бөгөөд эдгээрийн бие даасан байдал, хоорондын үйл

ажиллагааны харилцаа уялдаанаас түүний амьдрах чадвар, хөгжлийн хандлага, хурд, түвшин шууд хамаарна.

Дээр үзүүлсэн улсын хил хамгаалалтын тогтолцооны дэд тогтолцоо болох улсын хилийг хилийн хяналтын байгууллагуудын хүчээр хамгаалах тогтолцоог дараахь байдлаар дүрсэлж болно гэж үзэж байна.



Энэхүү тогтолцоонд багтаж байгаа албад нь өөр өөрийн үндсэн чиг үүрэгтэй хэдий ч тэдгээрийг нэгдмэл цогц байдлаар авч үзвэл хилийн боомтод үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулж байгаа болно. Улсын хил хамгаалалтын тогтолцоонд хилийн хяналтын албад тодорхой байр суурь эзэлж байдаг. Тэр тусмаа хилийн боомтод хилийн хяналтын байгууллагуудаас үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бололцоог нь хилийн шалган нэвтрүүлэх алба хангаж өгдөг. Хилийн шалган нэвтрүүлэх алба нь хил хамгаалалтын үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Сүүлийн жилүүдэд шалган нэвтрүүлэх албаны үүрэг улам ихээр өсөн нэмэгдэж байгааг доорхи бодит жишээ баримт тодорхой харуулж байна.

Дэлхийд их гүрэнд тооцогддог Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард улстай хиллэсэн Монгол Улсын 8162 километр урт хилийн дагуу өнөөдрийн байдлаар олон улсын агаарын замын 2, төмөр замын 3, автозамын 37 хилийн боомт ажиллаж байна. Сүүлийн 5/1996-2000/ жилийн үзүүлэлтээс авч үзвэл жилд дунджаар 1 000 000 орчим зорчигч, 320 000 орчим тээврийн хэрэгсэл, 450 000 шахам

үйлчлэх бүрэлдэхүүн нэвтэрчээ. Эдгээр тоо юуг өгүүлнэ вэ гэдэг нь сонирхолтой байгаа юм.

Тухайлбал улсын хилээр нэвтэрч байгаа зорчигчийн ихэнхи нь хэн бэ гэдгийг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн 1992 оны Хүний хөгжил илтгэлд дурдсанаар тодорхойлж болох юм. Уг илтгэлд: "Дэлхийн 5,7 тэрбум хүний 2 тэрбум гаруй нь ядуу зүдүү амьдарч байгаа бөгөөд тэдгээрийн үнэлэхүй олонхи нь Ази, Африк, Латин Америкийн хөгжиж байгаа орнуудад байна. Ядуу орны ядуу хүмүүс нь амь зуухын тулд тухайн орондоо болон улс хоорондох хүний хөдөлгөөний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж байна. Энэ нь жилээс жилд өсөж байгаа болно.

Нүүдлэн шилжигчдийн дунд цагаачдын эзлэх хувь өсөж байна. Хөгжиж байгаа орнуудад хөдөлмөрийн чадвартай хүмүүсийн 40 хувь нь ажилгүй байна. Статистикийн тоон үзүүлэлтээс харж болох юм.

Явуулж байгаа болон хүлээн авч байгаа цагаачдын тоогоор эхний 10 орж байгаа орнууд

ЦАГААЧДЫН ТОО/50 000 ОРЧИМ/	
Төрөлх орон	
Афганистан	3 400 000
Палестин	2 800 000
Рванда	1 700 000
Югослав/хуучнаар/	1 400 000
Либерн	750 000
Сомали	450 000
Судан	400 000
Ангола	350 000
Еритри	350 000
Вьетнам	300 000
Хүлээн авч буй орнууд	
Иран	2 000 000
Пакистан	1 500 000
Заир	1 400 000
Жордан	1 100 000
Газа Стрип	600 000
Судан	600 000
Танзани	600 000
Гвиней	550 000
Вест Банк	500 000
Герман	400 000
Эх материал: АНУ-ын цагаачлалын асуудал хариуцсан Хороо, 1995 он	

ЭН

ихэнхи нь ядуу, тэнүүлчин цагаачид байдаг учраас тэдний зүгээс үндэсний аюулгүй байдалд ямарч хор уршиг, аюул занал учруулж болзошгүй юм. Одоогийн байдлаар Монгол Улс баруун Европын орнуудад цагаачлахын, санаархагч хятад, солонгосчуудын түр саатдаг. Монгол Улсын иргэнд олгодог гадаад паспорттой болж аваад дамжин өнгөрдөг талбар болоод байгаа нь нууц биш юм.

Шалган нэвтрүүлэх албанд дэлхийн хүн амын өсөлтийг ч тооцох хэрэгтэй/ Жич: НҮБ-аас гаргасан тооцоогоор дэлхийн хүн ам 2000 онд 6,3 тэрбумд, 2050 онд 9,8 тэрбумд хүрнэ/.

Монгол Улсын хилийн боомтоор түүхий эдийн нөөц, материалын үнэт зүйлийг хатуухан хэлбэл Монгол улсын үндэсний баялгийг үлэмж их хэмжээгээр хууль бусаар гадагш зөөх оролдлогыг бууруулахгүй байгаа олон улсын харилцааны болон худалдааны харилцааны субъектүүдийн тоо байгаагүйгээр өргөжиж байна. Хилийн боомтоор нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд нэмэгдэхийн хирээр хилийн хяналтын албадуудын үйл ажиллагаа боловсронгуй болох зайлшгүй шаардлагатай юм. Өнөөдрийн байдлаар хилийн хяналтын албадуудын хамтын ажиллагаа төдийлөн хангалтай бус байна. Энэ нь олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа нь тодорхой боловч хамгийн гол нь удирдлагын салангад тогтолцоотой шууд холбоотой гэж үзэж байна. Төрийн тусгай үүрэг гүйцэтгэж байгаа шалган нэвтрүүлэх албаны хувьд үйл ажиллагааны нэг ч алдаа, дутагдал гаргахгүй байх ёстой хэдий ч тус албанд зерчил дутагдал арилахгүй байна. Улсын хил хамгаалалтын тогтолцооны дэд бүтцэд багтаж байгаа шалган нэвтрүүлэх албыг байгууллага гэж үзвэл түүний нөөцийн байдлын талаар дурдахгүй өнгөрч болохгүй. Үүнд:

1. Хүний нөөц:

Шалган нэвтрүүлэх албанд ажиллаж байгаа офицер, ахлагч нарын 60-аас дээш хувь нь албаныхаа чиглэлээр мэргэжлийн болон мэргэшүүлэх тодорхой дамжаа төгсөөгүй, хар практикаар явж байгаа нь албаны үйл ажилагаанд сөрөг нөлөө үзүүлж байгаа нь нууц биш юм. Шалгагчдын гадаад хэлний мэдлэг сулаас 1990 оноос хойш хуурамч бичиг баримттай явсан 3 улсын 4 иргэнийг Замын-Үүд, Сүхбаатарын хилийн боомтоор нэвт алдаж, ОХУ-ын талаас хүлээн авсан.

2. Санхүүгийн нөөц:

Сар бүр төрөөс олгодог төсвөөс өөр санхүүжилтгүй байгаа нь мөнгөгүй хүн, аж ахуйн нэгж, байгууллага юу ч хийж чаддаггүйтэй утга нэг юм.

3. Материалын нөөц:

1960-1970 оны үеийн ЗХУ-ын шалган нэвтрүүлэх албаны техник хэрэгсэл нь нэгэнт хуучирч, хоцрогджээ. Жишээ нь аль нэг улсаас хэн нэгэн иргэнээ манай улсад очсон үгүйг лавлахад бараг 7 хоног эрээд ч тогтоож чадахгүй. Би энд компьютерийн дотоод, гадаад сүлжээ байхгүй гэж яривал нэлээн өндөр хөгжил шаардсан болно. Зорчигчдоор бөглүүлж хадгалдаг "Оров", "Гарав" хуудас дээрх өгөгдөхүүнүүдийг хоног алдан компьютерт шивж байгаа хэдий ч хайлтын программ байхгүйгээс хайлтыг гараар хийж байна. Хилийн боомтууд шалган нэвтрүүлэх албанд шаардлагатай инженерийн төхөөрөмжгүй байна.

4. Технологийн нөөц:

Албыг зохион байгуулан удирдах 3 орчим хувилбар байдаг хэдий ч хилийн манаа, хүн бүрийн нэгж хугацаанд гүйцэтгэх ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй тогтоогоогүй гэхэд хатуудахгүй бизээ. Шалган нэвтрүүлэх албаны менежментийг нэн яаралтай хийх цаг болсон гэж үзэж байна. Менежмент хийгээгүйгээс офицер, ахлагч хоёрын гүйцэтгэх үүрэг, эрх мэдэл, хүлээх хариуцлага тодорхой бус, мөн хилийн шалган нэвтрүүлэх зарим заставуудын офицер, ахлагч нар шалгалтын бус цагаар хийх зүйлээ олж ядах үзэгдэл түгээмэл байна.

Азийн автозамын сүлжээнд нэгдсэн хийгээд, дэлхийчлэх үйл явц, улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хийгдэж байгаа Монгол Улсын хэвтээ, босоо тэнхлэгийн дагуу баригдах авто зам болон бусад олон хүчин зүйлээс улбаатайгаар улсын хил хамгаалалтын үүрэг эрс нэмэгдэж, шалган нэвтрүүлэх албанаас цаг хугацаатай уралдан, шуурхай үйл ажиллагаа шаардагдах болно.

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, хилийн боомтод хилийн аюулгүй байдлыг хангахын тулд дараахь асуудлыг ойрын ирээдүйд шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна.

- Хилийн Цэргийг Удирдах Газрыг Засгийн Газрын аль нэг сайдын эрхлэх асуудлын хүрээний яамны мэдэлд бус Засгийн Газрын бие даасан Хил хамгаалалтыг удирдах газар болгон өөрчлөх, хил хамгаалалтын удирдлагыг либеральчлах чиглэл баримтлах,
- Хилийн боомтын үйл ажиллагааг зохион байгуулж удирдах эрх, мэдлийг хилийн шалган нэвтрүүлэх албанд хуульчлан олгох,
- Улсын хил хамгаалалтын, ялангуяа хилийн шалган нэвтрүүлэх албаны дэд бүтцийг бүрдүүлэх, хилийн болон шалган нэвтрүүлэх отряд, заставын нөөцүүдийг өнөөгийн хэрэгцээ, шаардлагын түвшинд бий болгох, тэдэнд жилийн санхүүжилтыг бүтнээр нь оны

- эхэнд олгож байх, санхүүжилтын бусад эх үүсвэр олох эрх олгох,
- Хилийн болон шалган нэвтрүүлэх отряд, заставын зохион байгуулалтын бүтцийг нэг хэвшмэл шугаман бүтэцтэй бус цагийн байдлын ямарч нөхцөлд зохицуулан хувиргаж болохуйцаар тогтоох,
 - Хилийн Цэргийн байнгын бие бүрэлдэхүүнд тасралтгүй боловсрол, мэргэжил олгох, мэргэжил, мэргэшлийн түвшин дээшлүүлж байхаар албан ба албан бус боловсролын тогтолцооны боломжит хэлбэр, аргуудыг ашиглах,
 - Хилчдийн ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог бүх талаар хангах асуудлыг хилийн болон шалган нэвтрүүлэх харуул, ээлж, заставаас эхлэн шийдвэрлэх,
 - Улсын хил хамгаалалтад төрийн болон төрийн бус байгууллага, нэгж, иргэдийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг өндөржүүлэх,
 - Улсын хил хамгаалалтын хяналтын тогтолцоог жинхэнэ ёсоор бүрдүүлэх зэрэг болно.

*

*

*

Доктор /PhD/, дэд профессор Г.Дагважамц

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТӨД ЦЭРЭГ-УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Улсын хил хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгоход зайлшгүй нөлөөлдөг хүчин зүйлийн нэг нь цэрэг-улс төрийн нөхцөл байдал юм.

Тэгвэл өнөөдөр цэрэг-улс төрийн байдал чухам ямар байна вэ? Өнөөдөр ертөнц хоёр туйлт хуваагдалгүй болов. Улс орнууд тэдгээрийн дотроос манай хөрш хоёр орны гадаад бодлого, цэрэг-стратегийн салбарт баримтлах үзэл баримтлал өөрчлөгдлөө.

Аль аль нь олон тулгуурт бие даасан гадаад бодлого явуулж дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, зэвсэгт хүч, зэвсэглэлийг хорогдуулах, батлан хамгаалах зорилго нь зөвхөн өөрийгөө хамгаалахад чиглэгдэх болсон.

Гэлээ ч гэсэн энэ байдлыг шинэ хуучин хоёр зууны зааг дээрээс цэгнэж үзвэл нийгмийн санаа бодол алив мөргөлдөөнийг хүчээр шийдвэрлэх гэсэн хуучинсаг үзэл давтагдав.

Хүн төрөлхтний түүхэнд хамгийн их дайнч, цус асгаруулсан зуун бол XX зуун болов. Энэ зуунд дайн зэвсэгт мөргөлдөөний давтамж